

**ЛИВАНЫ ЭСРЭГ ДАЙН:  
ШАЛТГААН, ЯВЦ, МӨН ЧАНАР**

**Д. Маам**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Израилийн булаан эзлэгчдийн шатаасан дайны утаа замхарч амжаагүй, журам сахиулах нэрийн дор Ливанд шургалан орж ирсэн америкийн далайн явган цэрэг энд тэндгүй байрлаж нийслэлийг хараачилан хянаж буй хүнд нөхцөл дор 1982 оны 11-р сарын 22-нд Бейрутын төв өргөн чөлөөнөө засгийн газрын цэрэг, эх орноо хамгаалах бүх хүчний төлөөлөгчдийн жагсаал болж, Бүгд найрамдах улсын ойг өндөр ёслолтойгоор тэмдэглэсэн билээ. Энэ бол нөгөө талаас Францын колоничлогч цэргийн шилийг харснаас хойш 36 жилийн дараа Бейрут хот түрэмгийллийн давамгайл хүчинд арга буюу автаж, харийн цэргийг босго алхуулсан хэдий боловч ялагдан сөгдөлгүй, харин ч улсын нийслэлийн үүргээ нэр төртэйгээр гүйцэтгэж байгаа, мөн дэлхийн сайн санаат улс түмний өмөг туслацаа авсан Ливаны ард түмэн нийтээр түрэмгийллийг зогсоож чадаад дайсныг нутаг орноосоо хөөн зайлуулах сөрөг алхам нэгэнт эхэлснийг харуулсан нотолгоо боллоо.

Дэлхийн I дайны төгсгөлийн баримт бичиг болох «Версалийн найрамдлын гэрээ» байгуулсан империалист гүрнүүд дэлхийг дахин хуваах улс дундын монополист бодлогоо «асрамжийн мандат эрх» хэмээх хуурамч багаар халхлах арга саам зохион хэрэгжүүлснийг нийтээр мэднэ. Версаль маягийн найрамдал, ёсоор Ливан орон Францын империализмын «асрамжинд» очжээ. «Асрамжийн мандат эрхийн» империалист агуулга, колоничлолын мөн чанарыг В.И.Ленин бүр 1919 оны 11-р сарын 22-нд Дорно дахины ард түмний коммунист байгууллагуудын бүх оросын II их хуралд тавьсан илтгэлдээ: «Колониудад асрамжийн эрхийн бичиг тараах тухай ярьж эхэлмэгц л энэ нь тонох дээрэмдэх эрх олгосон зөвшөөрөл, энэ нь ертөнцийн хүн амын өчүүхэн жижиг хэсэгт хүн төрөлхний ихэнхийг шулан мөлжих эрх олгосон зөвшөөрөл гэдгийг бид чухам сайн ойлгож байсан» гэж тодорхойлсон бөгөөд ЗХУ «мандатын» системийг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй билээ.

Османы эзэнт гүрний задралтай нэгэн зэрэг Ливан болон арабын өөр хэд хэдэн орон колоничлолын системд хүчээр нэгтгэгдэх болсон хийгээд 1918 оны 10-р сард англи-францын цэргийн ангиуд Ливанд цөмрөн оржээ. Чингэж дэлхийн I дайн колонийн шинэ эзэмшлийн төлөө цааш үргэлжлэхэд Ливан орон эн тэргүүн хэлмэгдэн хохирч, францын дээд захирагч гэгчийн эрхшээлд орсны дээр эзлэн түрэмгийлэгчид 1920 оны 9-р сарын 1-нд францын асрамжин дахь «Аугаа их Ливан» гэгчийг тунхагласан юм. Тоглоомын засгийн газар байгуулах замаар эзэгнэн захирах ажиллагаа лавшруулахад чиглэгдсэн францын колоничлогчдын бодлогыг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн 1924 оноос өрнөж эхэлсэн бө-

гөөд Бекаагийн хөндийд гарсан том бослого, мөн онд Сири-ливаны коммунист нам байгуулагдсан ээрэг явдал Ливаны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хөгжилд доривтой алхам, хойш хойшдын хэрэг явдалд ул мөрөө үлдээсэн томоохон үйл явдал болсон юм.

Ливанчууд 1943 оны 11-р сарын 22-нд улс орныхоо тусгаар тогтнолыг тунхагласан хэдий боловч ЗХУ гол хүндийг нь үүрч шийдвэртэйгээр явуулж төгсгөсөн II дайны эцэс хүртэл мандатаар колоничлогчид араб дахиныг орхиж явах тухай бодоо ч үгүй байлаа. Ливаны нутгаас францын сүүлчийн цэрэг 1946 оны 12-р сарын 31-нд гарчээ.

Ливанд Османы ноёрхол унахад мандатын нэрээр антантын колоничлол эхэлсэн шиг, антантын франц, Ливан орноос цэргээ татахад II дайнаар хөлжиж хүчирхэгжсэн дэлхийн хамгийн сувьдаг, хамгийн харгис хүчин америкийн империализм Ливанд францыг байр суурийг уламлан орлох бодлогоо ирмүүнээр явуулж эхэлсэн байна.

1948 онд Ливаны засгийн газар АНУ-тай Ливаны нутгийг дайруулан нефть дамжуулах хоолой тавих тухай хэлэлцээр байгуулсан бөгөөд «Трумэны номнол» гэгчийн үндсэн дээр даруй 10 жилийн турш Вашингтон Ливаныг «туслаж, асрамжилсан нь»<sup>2</sup> уул орон америк маягийн колоничлолын нөлөөний хүрээнд татагдан орох эдийн засгийн боломжийг нөхцөлдүүлжээ. Гэтэл Америкийн империализмын зүгээс Ливаны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох явдал ба АНУ-ын тал барьсан өөрийн засгийн газрын бодлогыг эсэргүүцсэн Ливаны ард түмний шударга тэмцэл өрнөж байсан 1958 онд АНУ Ливанд цэрэглэн халдаж байв. Америкийн империализм Ливаны улс төр, эдийн засгийн бүрэн эрхт байдлын эсрэг үйл ажиллагаандаа израилийн дайнч сионист бүлгийг зэвсэглэн ашиглах тактик хэрэглэсээр ирлээ. 1943-1973 онд Ливан улсын засгийн газар даруй 40 удаа халагдаж солигдсоны учир шалтгаан Ливаны нийгмийн дотоод зөрчлийн хурцдал, тухайлан засгийн эрхийн төлөө тэмцэлд оршиж байсан боловч АНУ ба америк-израилийн хуйвалдааны үр дүн болж арабын эл оронд засгийн эрх солигдсон цөөн бус тохиолдлыг нэрлэн зааж болох билээ. Израилийн зүгээс Ливанд үзүүлэх дарамт шахалт жилээс жилд нэмэгдсээр зөвхөн 1973 оны 1-8-р сард 100 гаруй удаа зэвсэгт өдөөн хатгалга үйлджээ.

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дотроос нь задлах явдал Ливаны эсрэг хүчнүүдийн шалгарсан арга болохыг 1982 оны түрэмгийллээс урьд Ливаны өмнөт хил дээр бүрэлдэн тогтсон байдал дахин нотолсон юм. Израилийн дайнчдын олон удаагийн өдөөн хатгалга, 1972, 1978 оны цөмрөлтийн тодорхой нэг үр дагавар бол Эль-Литани голоос Ливан-израилийн хилийг хүртэлх зурвас нутагт салан тусгаарлагчдын явуулж ирсэн хорт ажиллагаа байв. Хэрэг дээрээ израилийн зэвсэгт хүчний дайвар, салбар анги болох тэр бүлэг хүмүүс хошууч Хаддат гэгчийн удирдлагын дор төв засгийн газарт шууд дайсагнан, хяналтандаа авсан зурвас нутаг дээрээ «чөлөөт Ливан» гэгдэх «улсыг» тунхаглажээ.

Өмнө зүгийн нутгийн байдлыг Ливаны нэг дэх хагарал гэж үзвэл, хоёрдахь хагарал нь нийслэл Бейрутыг дайрч өнгөрч байгаа юм. Хотын зүүн тал хэсэг, зүүн хойт нутгийн зурваст байрлах баруун христианчүүд «Ливаны фронт» хэмээх бүлэг хүчинд ялгаран нэгдсээр бас л хэдэн жилийн нүүр үзэж буй билээ. Энэхүү бүлэг хүчний тэргүүнд хуучныг баримталсан катаиб, «өөрийгөө тусгаарлагч» хочтой үндэсний либерал-хөрөнгөтний зэрэг нам орж байгаа явдал эх орны нэгдсэн фронт бүрэлдэн тогтох явцад аюултай хориг болж буй төдийгүй ангийн эрх ашиг нь

Ливан үндэсний эрх ашгийг давамгайлсан тэрхүү хуучныг баримтлагчид тухайлан Ливаны, ерөөс араб дахины хэрэг явдал дээр дэлхийн империализм, израилийн талын бодлого баримталсаар, тэр хүчнүүдтэй ажиллагаагаа уялдан зохицуулсаар иржээ.

«Цагдан сэргийлэхийн ангиуд» гэж нэрлэгдэх боловч хэрэг дээрээ армийн зохион байгуулалттай олон мянган хүнтэй бие даасан зэвсэгт хүчин бүхий «Ливаны фронтынхны» эсрэг галын хүч бол Баруун Бейрут нутгийн хойт, баруун хойт талаар сууршин бүхий үндэсний эх оронч хүч юм. Ливаны хүн амын ихэнх нь болох лалын шашинтан болон 1948, 1967 оны дайнд израилчуудад мөрдөн хөөгдөж Ливанд шилжин нутагшсан 350 мянган палестин, мөн Палестины чөлөөлөх байгууллага Ливаны үндэсний эх оронч хүчний талд хатуу зогсож байлаа.

Ливан ийнхүү харилцан дайсагналцсан хэд хэдэн хэсэг болон задарсан явдал израиль-америкийн түрэмгийллийн төлөвлөгөөг зохиогчидод ноцтой анхаарагдсан юм. 1982 оны 12-р сард Израилийн батлан хамгаалах яамны сайд Шарон Тель-Авивын стратеги судлалын хүрээлэнд болсон цэрэг-улс төрийн өндөр тушаалтнуудын зөвлөлгөөн дээр хэлсэн үгэндээ Израилийн «аюулгүй байдлын» номнол гэгч зүйлийг дэвшүүлж гаргасан билээ. Түүгээр бол Израил өөрийн аюулгүй байдлын төлөө «урьдчилсан сөрөг алхамууд хийж» нөлөө, ашиг сонирхолынхоо хүрээг арабын орнуудаар зогсохгүй Турк, Иран, Пакистан, Персийн булан, хойт ба төв Африкт тогтоох ёстой гэнэ. Энэ бол Израилийн 80-аад онд хийж гүйцэтгэх стратегийн холбогдол бүхий үйл ажиллагаа мөн гэж Шарон тэгэхэд илэн далангүй тэмдэглэсэн<sup>3</sup> ажээ. Хоёр сарын дараа «Джорнэл оф джудаизм энд зайнизм» сонин Овед Йинон гэгчийн бичсэн өгүүлэлд Шароны мэдэгдлийг нарийвчлан тайлбарласан нь дэлхий нийтийн анхаарал татахад хүрсэн юм. Тэнд «..угсаатны олон янзын цөөнхөөс бүрдэх, мөн дотоод хямралдаа идэгдэн задарсан араб ертөнн өөрийн үндсэн асуудлыг шийдвэрлэх тэнхэлгүйн дээр чухамдаа хэдийд ч гэлээ бидэнд аюул занал учруулж, хөндөлдөн зогсож чадахгүй»<sup>4</sup> гэж нотлон өгүүлээд, түрэмгийллийн бодлогын золиосонд эн тэргүүн Ливаныг нэрлэн зааж, тус орныг 5 жижиг муж буюу бичил улс болгон тасчих хэрэгтэй<sup>5</sup> мэтээр бичсэн байлаа.

\* \* \*

АБНЕУ, ЗХУ-ын хооронд тогтсон найрамдал, хамтын ажиллагааны гэрээг 1971 онд Каир дур мэдэн гагцаар цуцалж, улмаар Кэмпдэвидийн хэлэлцээрийг байгуулан арабын үндэсний хөдөлгөөнөөс салан тусгаарласан зэрэг Ойрхи Дорно дахинаа болсон сөрөг үйл явдлууд түрэмгийллийн замд ногоон гэрэл асаажээ. Ялангуяа А. Садат 1979 оны 11-р сарын 19-нд Иерусалимд очиж<sup>6</sup> Израилийн дайнчдын өмнө буулт хийсэн явдал сионизмын удирдагчдыг сүүл хатгуулахад хүргэсэн гэдгийг онцлон тэмдэглэлтэй. 1982 оны 6-р сарын түрэмгийлэл египет-америк израилийн гурамсан хуйвалдааны бүхэл үйл явцаар шатлан өргөжиж бэлтгэгдсэн бөгөөд тодруулж хэлэхэд Кэмп-Дэвид байгаагүйсэн бол Ойрхи Дорно- тын 5 дахь дайн өнгөрсөн зун шатах үндэс нөхцөлдөн бүрэлдэх учиргүй байлаа. Энэ утгийн үүднээс ерөнхийлөгч агсан Садат түүний хань хамсаатнуудын урвагч бодлого түрэмгийллийн ноцтой нэгэн хүчин зүйл болж өгчээ гэдэг дүгнэлт аяндаа гарч ирж байгаа юм.

3. «За рубежом», № 43, 1982, с. 10.

4. Мөн тэнд.

5. Мөн тэнд.

6. Международная жизнь», № 5. 1981, с. 31

1977 оны 12-р сарын 2-5-нд Триполид Сири, БНАЙАУ, Алжир Ли ви, ПЧБ-ын удирдагчид зөвлөлдөж «хатуу зогсолт, сөрөг үйл ажиллагааны үндэсний фронт» буюу Тавын хороог байгуулсан бөгөөд мөн арабын 17 орны олон нийтийн 140 байгууллага, улс төрийн 72 нам нэгдэж Кэмп-Дэвидийн эсрэг Бүх арабын Конгрессыг дээрхи үндэсний фронттой зэрэгцүүлэн үндэслэсэн зэрэг эерүү талын олон тодорхой үйл явдал сүүлийн жилүүдэд Ойрхи Дорно дахинаа болсныг нийтээр мэднэ. Гэвч Араб дахин тухайлан Ливаны асуудал дээр Ирак-ираны мөргөлдөөн харамсам хор холбогдол бүхий үүрэг гүйцэтгэсэн билээ.

А. Садат Египет болоод бүх арабын нэр хүндийг түрэмгийлэгчийн өмнө доромжлон гутаасан албан баримтад гарын үсэг зурсны дараах өдөр Иракийн нийслэл Багдад хотноо Арабын орнуудын гадаад явдал, эдийн засаг, санхүүгийн яамдын сайд нарын онц яаралтай зөвлөлгөөн болж Египетийн дэглэмийн эсрэг улс төр, эдийн засгийн хориг арга хэмжээ авахаар тогтсон бөгөөд Оман, Судан, Сомалиас бусад Арабын холбооны бүх улс Онц зөвлөлгөөний тогтоолд гарын үсэг зурсан юм. Дэлхий нийт, тухайлан арабуудын жинхэнэ хань нөхөр-социализмын орнууд Иракийн нийслэлд чуулагчдын шийдвэртэй арга хэмжээг зөв замд хийсэн тодорхой алхам хэмээн баяртайгаар хүлээн авч билээ.

«Багдад хотноо гарсан шийдвэрүүд Ойрхи Дорнотын асуудлыг бодитойгоор зохицуулахын төлөө тэмцэлд жинтэй үүрэг гүйцэтгэнэ гэж миний бие үзэж байна»<sup>7</sup> хэмээн А. И. Брежнев дээрх уулзалтыг үнэлсэн байдаг. Гэвч ирак-ираны дайн арабуудын болоод тэдний хань нөхдийн дээрхийн адил мөрөөдөл найдлагат хүнд цохилт өгсөн төдийгүй мөн хэмжээгээр империализм-израилийн нэгдсэн хүчнийг баярлуулсныг өгүүлэх юун.

Дээр нэр дурьдсан «Джорнэл оф джудаизм энд зайнизм» сонинд «нефтийн баялаг орон» Ирак нь Израилийн «харааны бүсэнд» оршиж буйг нуулгүй дурдаад «Ирак улс ойрын ирээдүйд Израилийн өмнө хамгийн хүчтэй тээг болж мэдэх тул энэ орныг дотроос нь задлах явдал Сирийг дотроос нь задлахаас давуу ач холбогдолтой байна. Сири-иракийн хооронд дайн үүсдэгсэн бол тийм дайн ийм хагарал гарахад (тун хэрэгтэй... Ерөөс арабуудын ямар ч мөргөлдөөн араб ертөнцийн бутралыг түргэсгэж өгөх учир ашигтай байх болно. Эдүгээ явагдаж буй Ирак, Ираны хоорондын дайн ч ялгалгүй чухам арабын хагарал бутралын туйлыг ойртуулж байж мэдэх юм»<sup>8</sup> хэмээн тэмдэглэжээ.

\* \* \*

Баримт материалыг анхааралтай ажиглахад Ливаны эсрэг хийх Израилийн түрэмгийллийг АНУ шууд бэлтгэлцсэн нь тод байна. Нэн тэргүүнд тэмдэглэвэл зохих зүйл бол Рейганы засаг захиргаа Израилийн түрэмгийлэлд сөрөг үйлдэл үзүүлж болох Ойрхи Дорнотын хүчнүүдийг дипломат арга заль, зэвсэглэлийн наймаагаар зохицуулж, шинэ түрэмгийлэлд тэднийг сэтгэл санааны хувьд «бэлэн байлгах» талын элдэв оролдлого хийсэн явдал болно. Америкийн империализм сүүлийн жилүүдэд зөвхөн Египетэд 3,5 миллиард долларын зэвсэг нийлүүлээд байгаа бөгөөд АНУ-ын зэвсгийн сангаас сөнөөгч онгоц «Эф16», «М-60» маягийн хүчирхэг танкууд, залуурт «Хок» пуужингийн цэнэг, хуягт, ачигч нисдэг тэрэг<sup>9</sup> зэрэг хамгийн орчин үеийн зэвсэг Нилийн эрэг рүү ачигдаж бай-

7.Л. И. Брежнев. Ленинским курсом Речи, приветствия, статьи, воспомина. ния М . , 1981, т. 7. с. 522

8. «Международная жизнь», № 5, 1981, с. 31.

9. «Международная жизнь», № 12, 1981, с. 124.

гаа юм. Персийн булангийн орнуудыг америкийн зэвсгээр худалдан авч Израилийн тухайд төвийг сахиулах тактик АНУ-ын гадаад бодлогод ялангуяа түрэмгийллийн өмнөх үе ноцтой ажиглагдаж байлаа. Улаан далайн эрэг дэх Египетийн Рас-Банас баазыг шинэчлэн зэвсэглэхэд пентагон 400 сая доллар зарсан<sup>10</sup> бол английн «Файнэншл Таймс» сонины мэдээлснээр Бахрейн, Катар, Арабын нэгдсэн Эмират, Оманыг оролцуулан цэргийн эвсэл холбоо хүртэл байгуулахыг санаархаж буй ажээ.<sup>11</sup>

Нэгэн зэрэг АНУ-ын засаг захиргаа «зөвлөлтийн аюул» гэгч сэдвийн дор араб дахиныг хууран мэхлэх үзэл суртлын том кампани зохион явуулсан билээ. Тухайлан 1981 оны 4-р сарын эхээр Ойрхи Дорнодоор аялсан А. Хейгийн аялалыг жишээ болгон татаж болно. Тэрвээр Египетээс Пакистан хүртэлх баруун өмнөд Азийн бүх нутагт ЗХУ аюул занал учруулж байгаа бөгөөд Израиль нь арабуудын нэгэн адил дээрх аюулд хэлмэгдэн сүйрэх болзошгүй тул араб-израиль хоорондоо мөргөлдөх бус харин «стратегийн холбоотойгоор<sup>12</sup> Москваг эсэгүүцэх ёстой гэдэг санааг улиглан давтаж явсан юм.

Одоо Израилийг аваад үзье. Сионизмын түрэмгий улс Ойрхи Дорнодод тав дахь дайны галыг шатаах бэлтгэлээ шатлан өргөжүүлэх тактикийн хувьд хоёр замаар явуулжээ. Үүнд нэгдүгээрт, Иерусалимыг Израилийн албан ёсны нийслэл болгон зарлаж, Сирийн Голланы өндөрлөгийг «израильчилсныхаа» дараа «Мөлхөө маягийн хавсарган нэгтгэх» бодлого гэгчийн үндсэн дээр Иордани голын баруун эрэг, Газын бүсэнд еврейн тосгод байгуулах ажиллагаагаа идэвхжүүлсэн амуй. Хоёрдугаарт Ливаны нутаг дахь Палестины энгийн номхон ард иргэд, ПЧБ-ын байрлалтад их бууны гал, агаарын, дайралт, цэргийн цөмрөлтөөр байнга аюул занал учруулж байлаа.

Гэтэл Израиль эзэлсэн газар нутагтаа еврей нарыг суурьшуулан израилчилах чиг шугамыг АНУ дэмжихийн зэрэгцээ<sup>13</sup> Ливан дахь палестин дүрвэгсэдийн хуаранг довтлох явдлыг зөвтгөхийг оролдож байна.<sup>14</sup> Ливаны эсрэг явуулж байгаа өдөөн хатгалгын түрэмгий үйл ажиллагааг Рейганы засаг захиргаа ийнхүү өөгшүүлэн дэмжиж буй нь Ливаны эсрэг түрэмгийлэлд АНУ, Израиль хоёр хамтран бэлдсэнийг санамсаргүй илчилсэн «дипломат ташаарал» бус, харин ч «америк-израилийн стратегийн холбоо хэлхээ» гэгчээр арабуудыг сөргөж сээрэлхсэн өдөөн хатгалга байжээ гэдгийг өгүүлэлтэй.

Ойрхи болон Дундат Дорнод Умард Африкийн сав газрыг эзэгнэж пакистан-судан-турк хэмээх гурван өнцгийг холбосон Израилийн их империалист гүрнийг байгуулах сионист санаархал<sup>15</sup>, Израилийн эдийн засгийн хүнд бэрхшээл аль аль нь АНУ-ын зүгээс Бегинд үзүүлэх дипломат болон бусад төрлийн дэмжлэг, нэгэн зэрэг Израилийг империалист бодлогынхоо улам бүр дуулгавартай зэвсэг болгон авах зорилгоор учруулах дарамт шахалтыг идэвхжүүлжээ. Израилийн эдийн засагт капитализмын эдийн засгийн нийтлэг хямрал гүнзгийрч мөнгөний ханш буурах явдал улсын түүхнээ рекорд (200%) төвшинд хүрч өнгөрсөн жил ажилгүйдэл 67% нэмэгдэж, цалин 14%-иар буурахын зэрэгцээ 1980 онд 30 мянган хүн Израилийг орхиж гадагш дүрэвсэн бөгөөд санал авалтын дүнгээс үзэхэд улсын иргэдийн 11% нийнхүү дүрвэн гарахад бэлэн байгаа аж. Түүнчлэн гадаадад төлөх өрийн хэмжээгээр Тель-Авив дэл-

10. «Международная жизнь», № 3, 1981, с. 121.

11. Мөн тэнд.

12. «Международная жизнь», № 7, 1981, с. 51.

13. Мөн тэнд с. 51.

14. Мөн тэнд.

15. Оded Ииноны дээр иш татсан өгүүллийг үз.

хийд дээгүүрт орох болсон нь хүүхдийг оролцуулан нэг хүнд даруй 6 мянган доллар<sup>16</sup> ноогдож буйгаас тодорхой байна.

Эдгээр зөрчлийн хурц үзүүрийг дайны цагийн хуулиар мохоож «шийдвэрлэх» бодлогот Израилийн засгийн газар шилжсэнийг АНУ дэмжиж буйг нотлох гэхийн хэрэггүй.

Ливаны эсрэг түрэмгийллийг бэлтгэх үеийн турш хоёр орон цэрэг зэвсгийн салбарт нягт хамтран ажиллажээ. АНУ-ын «Крисчйен Сайненс монитор» сонинд бичсэнээс үзэхэд Израилийн үндэсний орлогын тал шахам хувийг америкийн тусламж бүрдүүлж буй бөгөөд Израилийг цэрэгжүүлэн зэвсэглэх үйл явц шуударсан сүүлийн онуудад энэхүү «тусламжийн» хэмжээ жилд дунджаар 3 миллиард доллар болж өссөний 2/3%-ийг орчин үеийн дайны зориулалттай зэр зэвсэг эзэлж байв. Мөн АНУ-д төвлөсөн сионист байгууллагууд Израилийг «асран бөөцийлэх» явдлаа гүнзгийрүүлсээр түрэмгийлэл эхлэхийн өмнөх үе хүртэлх зөвхөн нэгэн жилийн дотор тусламжаа миллиардын хэмжээнд хүргэжээ. Америкчүүд Израилийн цэргийн баазуудыг өндөр хүч хурдтай хамгийн шинэ маягийн онгоцуудаар нөхөн хангаж дуусмагц Израиль түрэмгийллээ сая эхэлсэн тухай ноцтой баримтыг гадаадын олон хэвлэл тэмдэглэж байлаа.<sup>17</sup> Нэгэн зэрэг тэр үеэр хоёр орны цэргийн өндөр тушаалтнууд нууц хэлэлцээр байгуулах зэргээр олонт уулзаж зөвлөлдөж байсан нь сүүлд тодорхой болсон байна.<sup>18</sup> Тэр ч байтугай түрэмгийлэл эхэлсний дараа ч америкийн тал Израильд «эф-16» сөнөөгч бөмбөгдөгч онгоц 11-ийг оролцуулан 1,5 миллиард долларын цэргийн зэвсэг хэрэгсэл нийлүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн тухай 6-р сарын эхээр ЮПИ агентлаг мэдээлсэн билээ.

\* \* \*

НҮБ-ын цэрэг байрласан Ливаны өмнөт нутаг руу байнгын аюул занал учруулж өдөөн хатгалга хийх явдлаа 1982 оны 6-р сарын 6-ны өглөөний 6 цагаар тасалбар болгож, гал зогсоох тухай Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг Израиль улс хэрхэн биелүүлэхийг дэлхий нийтээр үзэх цаг тулж байлаа. Харамсалтай нь 6-р сарын 6-ны тэр өдөр нь Ойрхи Дорнотын олон улсын харилцааны түүхнээ дээрхтэй нэгэн зэрэг өөр нэгэн ноцтой үйл явдлыг тэмдэглэсэн түүхэн цаг хугацаа болж үлдсэн юм. Израилийн дайнчид Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх нь байтугай Ням гаригийн тэр өдрийн үдээс хойш Америкийн зэвсгээр иж бүрэн зэвсэглэсэн 25 мянган хүнтэй армиар Ливаны улсын хилийг цөмрөн орж уул орны газар шороон дээр зэрлэг түрэмгийлэл үйлджээ. Түрэмгийлэгчид баруун зүгт Тир хот, зүүн зүгт Шебаан, зүүн өмнөтөд Набатия хотын чиглэлээр чандмалан довтолсон бөгөөд хүчирхэг их буу зоосон танк, олон зуун онгоц, нисдэг тэрэг оролцсон агаарын болоод Израилийн далайн флотын хөлөг онгоцны нэгдсэн их хүч газар, агаар усаар явган цэргээ дэмжиж давшуулахаар дайныхаа төлөвлөгөөг зохиосон байв. Гэвч Ливаны үндэсний арми ПЧБ-ын цэргүүд үндэсний эрх чөлөөний ухамсар, эр зориг, баатарлаг явдлыг үлгэр жишээг үзүүлж зарим газраар түрэмгийллийг зогсоосон төдийгүй өчүүхэн ч атугай боломжийг ашиглан хариу давшилтад орж байсан аж.

Хэдхэн цагийн дараа Бейрутын босгонд тулж очно гэж хийсвэр тооцоолсон Бегин-Шароны бүлэг цэргийн тоогоо эхлээд 50-мянга, дараа нь 100 мянга, бүр сүүлд нь 120 мянгад хүртэл нэмэгдүүлжээ. Нөгөө талаар Израиль «цахилгаан дайны» төлөвлөгөө тасалдуулсан «өшөөг» эвдрэл

16. «Международная жизнь» № 3, 1981, с. 121.

17. «Международная жизнь», № 7, 1982. с. 118.

18. Мөн тэнд.

сүйдэл, аллага хядлагаар авах тактик явуулсан юм. Алжирын «Эль-Муд-жахид» сонины мэдээлснээр түрэмгийлэл эхэлсний эхний 14 хоногт эртний дурсгалт Сайд хот нурсан балгас болж, Тир хот газрын хөрснөөс арчигдан 14 мянган хүн алагдаж, 20 мянган хүн шархдан энгийн номхон 800 мянган ливан, палестинчууд орон гэргүй болж цагаачлах замд гарсан ажээ.

Израиль энэ фашист дайныг юу гэж хийгээ вэ? гэдэг аруулт аяндаа гарч байна.

1. Америкийн империализмээр дэмжүүлсэн израилийн дайнчдын тавьсан нэг үндсэн зорилго бол Ойрхи Дорнотын хямралын гол цөм зангилгаа олон асуудлын үндэс болох Палестины асуудлыг америкийн зэвсэг, сионист түрэмгий цэргийн хүчээр нэгэн мөр шийдвэрлэж дуусгах гэсэн явдал юм. Палестинчүүдийг хүйс тэмтрэхийн тул аймаглан устгах аллагаар гол шинж нь тодорхойлогдож байгаа энэ дайны үндсэн зорилтыг өөрөөр тайлбарлах аргагүй билээ. Оны эхээр Израилийн жанжин штабын дарга Эйтен хийх түрэмгийллийнхээ тухай битүүхэн яриад «Энэ дайн нь сүүлчийн дайн болох ёстой гэж миний бие үзэж байна» хэмээсэн ноцтой үгийг энд иш татахад илүүдэхгүй. Ливан дахь палестинчүүдийг хүйс тэмтрэхийн зэрэгцээ, Палестины чөлөөлөх байгууллагыг устгаж, Иордани голын баруун эрэг-палестины уугуул нутагт израиль маягийн «автономыг» байгуулах замаа чөлөөлж засахыг Тель-Авив нэгэн зэрэг хичээжээ. Палестины шинэ улс байгуулагдах явдлыг Израиль хэзээ ч «зөвшөөрөхгүй» гэж түрэмгийллийн үеэр Шароны хийсэн мэдэгдэл дээрхийг тухайлан нотолж байна.

2. Нутаг орондоо палестинчүүд, ПЧБ-ын төв гүйцэтгэх хороог байрлуулсан Ливан болон түүний ижил арабын бусад орнуудад олон арван миллиардаар хэмжигдэх эдийн засгийн болон, олон мянган хүн хүчний хохирол учруулж «гэсгээн шийтгэх» явдал америк-израилийн хамтын түрэмгийлэлд томоохон үүрэг холбогдол бүхий зорилт байв. Ливаны бүгд найрамдах улсыг хэсэгчилэн хуваах угийн бодлогоо энэ удаагийн дайнаар хэрэгжүүлэх гэж империализм-сионизм шийдсэн аж. 1967 оны дайнд Сирийн Голланы өндөрлөг, Иорданий вант улсын Иорданийн голын баруун эргийн нутгийг булааж авсан шигээ энэ удаад бүхэл Өмнөт Ливаныг тэр чигээр нь Израильд хавсарган нэгтгэх гэсэн ноцтой бод- лого юм. Дараах «бичил улсыг» нутгийн умард хэсэг, Бекаагийн талд байгуулаад, Ливаны Төв засаг захиргааны мэдэлд Бейрут хот, уулын жижигхэн районыг үлдээхээр түрэмгийлэгчид төвлөсөн байна.<sup>20</sup>

3. Арабын орнуудын холбооны дээд шийдвэр, Ливаны засгийн газрын хүсэлтийн үндсэн дээр Ливаны хилийн дотор байрлаж буй энх тайван сахиулах Сирийн цэргийн ангиудыг хэлмэгдэгч орон Ливанаас хөөн гаргах, болж үзвэл Сирийг сулруулж араб дахины харьцангуй хүчирхэг энэ улсыг Египетын араас Кэмп-дэвидийн хүрээнд татан оруулах явдал 6-р сарын 6-ны түрэмгийллийн нэгэн зорилго байв..

4. Өөрсдийнхөө зохион байгуулсан түрэмгийллийг шалтаг болгож олон «улсын зэвсэгт хүчин» гэгчийн бүрэлдхүүнд америкийн далайн явган цэргийг Ливанд шургалуулан бодлого Вашингтон-Тель-Авивын төлөвлөгөөнд томоохон байр эзэлж байлаа. Түрэмгийллийн эхэнд америкийн зэвсгийг израилийн цэрэг агсаж Ливанд цус урсган цөмөрсөн бол, 10-р сарын эхээр АНУ-ын цэрэг орж ирсэн нь<sup>21</sup> израилийн хамт америкийн империализм Ливаныг цэрэглэн эзэгнэх бодлого явуулж байгааг харуул-

19. «За рубежом». № 26, 1982, с. 7.

20. «Правда», 17 ноября 1982.

21. «Вашингтон пост», 10 октября 1982 г.

лаа. Энэ удаагийн хэрэг явдал бол зүгээр нэг израилийн ганцаарчилсан өдөөн хатгалга төдий бус Вашингтон-Тель-Авивын нэгдсэн төлөвлөгөөгөөр явагдсан хийгээд үндсэн агуулга нь фашист интервенцээр тодорхойлогдох түрэмгийлэл мөн гэдэг дүгнэлтийг бид дээрх баримтаас ургуулан хийж болох юм.

Ерөөс энэ дайнаар шалтаг болгож Араб Дорно дахинд цэрэг стратегийн байр сууриа бэхжүүлэх явдлыг Рейганы засаг захиргаа хэтийн зорилго болгож тавьсан нь улам бүр тодорхой болж байна.

\* \* \*

Дайсан эвдэхийн ихээр эвдэж, аймаглан устгах зэргээр алахын ихээр алсан боловч энэ бол ялалт биш байсан хийгээд тодруулж хэлбэл империализм-сионизмын нэгдсэн хүч түрэмгийлэлдээ зорилго болгож тавьсан зүйлээсээ нэгийг ч бүрэн бүтэн биелүүлж чадаагүй юм.

Олон улсын хамтын нийгэмлэг, бүх хүн төрөлхтний өмнө Америк-израилийн интервейнчид ганцаардлын туйлд хүрснээр түрэмгийллийн ялагдал эн тэргүүнд илэрлээ. Империализм-сионизмын фашизмчилагдаж буй мөн чанар, улс гүрэн цугаарт дайсагнасан үйл ажиллагааных нь шатлан өргөжиж байгаа аюул заналыг нийтийн өмнө ямар ч хаалт хамгаалалтгүйгээр 6-р сарын дайн дэлгэн тавьжээ. Өгүлэн бүхий үеийн турш Арабын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний дайснуудыг үзэн ядах үзлийн үндсэн дээр дэлхийн империализмын сөрөг нэгдсэн фронтын батжил бэхжил ажиглагдам хүчтэй өрнөв.

Үүний зэрэгцээгээр Израильчууд ердөө эхний долоо хоногт 1973 оны дайнд хүлээсэн хохирлоосоо илүү хохирол амсаж<sup>22</sup> эзлэн түрэмгийлэгч цэргээ 100 мянга хүртэл нэмэгдүүлж байсан баримт түрэмгийлэгчдийн хүлээсэн зэвсэгт хүчний ялагдлыг харуулж байгаа юм. Зөвхөн Ливаны нутагт байрласан Сирийн цэргийн ангиуд эхний цөөн хоногт дайсны 120 танк, хуягт машин хэд хэдэн пуужин буудлагын төв байр, 67 онгоц-нисдэг тэрэг устгажээ.<sup>23</sup>

Ливан орныг «бичил» жижиг улсууд болгон бутаргах төлөвлөгөөндөө дайсан хүрч чадаагүй юм. Их хэмжээний хохирол хүлээсэн боловч чухам хэрэг дээрээ дэлхийн сионизм-империализмын нэгдсэн хүчийг тогтоон барьж, сөрөг ажиллагаанд орсон Ливаны ард түмний зориг санааг илэрхийлж Ливаны Коммунист Намын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ж. Хауи: «эзлэн түрэмгийлэгч сүүлчийн цэрэг Ливаны газар шороог орхиж зайлах тэр мөчийг хүртэл тэмцэл тасралтгүй үргэлжлэх болно»<sup>24</sup> хэмээн саяхан мэдэгджээ. Ливаны ерөнхий сайд Ж. Ваззан мөн үеэр эх орныг нь таслан хуваах зорилгоо дайнаар биелүүлж чадалгүй хэлэлцээрийн замаар уг санаагаа гүйцэтгүүлэх хэмээсэн түрэмгийлэгчдийн ов мэхийг няцааж доорхи мэдэгдлийг хийлээ: «Ливаны бүрэн бүтэн байдлыг бүгд найрамдах улсын бүхэл хил хязгаарын дотор сэргээн тогтоох эрмэлзэл ливанчуудыг нэгтгэн, зангидаж байна»<sup>25</sup>

\* \* \*

Израилийн дайнчдыг америкийн империализм зэвсэглэхийн хир хэмжээгээр Ойрхи Дорно дахинд шинэ дайны аюултай байдал бүрэлдэн лавширч байгааг социалист орнуудын засгийн газрууд удаа дараа тэмдэглэж ирлээ. ЗХУКН-ын дээд чуулга уулзалт-XXVI их хурал энх тайвны

22. «Аль-Ба<sup>1</sup> ас» сонины мэдээнээс («Новое время» № 25, 1982, с. 13)

23. «Новое время» № 19 с. 23.

24. «Правда» 15 ноября 1982 г.

25. Мөн тэнд.

программдаа, өгүүлэн бүхий бүс нутгийн хэрэг явдалд нарийвчилсан дүн шинжилгээ өгсний дээр асуудлыг зохиуулах тодорхой санал дэвшүүлсэу билээ. Энэ бол Ойрхи Дорнотын асуудлаар энх тайвны бага хурал хуралдуулах явдал байв, ЗХУ, АНУ-ын оролцоотойгоор ПЧБ-ын төлөөлөгчдийг заавал байлцуулан, араб дахины сонирхогч бүх орны хийгээд израилийн төлөөлөгч хэлэлцээрийн ширээнд сууж НҮБ-ын дүрэм, олон улсын нэгэн тогтсон нийтлэг хэм хэмжээний үндсэн дээр асуудлыг тайван замаар шийдвэрлэж болох, шийдвэрлэх ч ёстойг харгалзан үзсэнд бага хурал хуралдуулах саналын гүнзгий ач холбогдол оршиж байгаа юм.

Сирийн «Аш Ша<sup>1</sup> аб» сонин: «Ойрхи Дорнот дахь мөргөлдөөнийг зохицуулах талаар Л.И.Брежневийн дэвшүүлсэн санал онцгой ач холбогдолтой байна. Олон улсын бага хурал хуралдуулах, хурлыг зохион байгуулах зарчмын хувьд уг санал Кэмп-дэвидийн хэлэлцээр, нэгэн зэрэг түүнийг нэмж бататгах гэсэн олон зүйлийу арга саам, заль мэхийг илчилэн няцаасан юм.»<sup>26</sup> гэжээ.

АНУ Израилийн дайнчдыг зэвсэглэж тухиран хатгаснаар бүрэн эрхт Ливан улсын эсрэг шинэ түрэмгийлэл дэгдсэн нь хүнлэг ёс, олон улсын шинэ маягийн харилцааны төлөө тэмцэл гадаад бодлогы нь тодорхойлж байдаг социализмын орнууд, хүн ардын сэтгэлийг гүнээ түгшүүлсэн билээ. Зөвлөлт засгийн газар 1982 оны 6-р сарын 14-нд нийтэлсэн мэдэгдэлдээ Израилийн энэ удаагийн дайны зорилго империализм-сионизмын хэтийн стратегийн бодлогоор тодорхойлогдож байгааг илчлэн харуулаад ЗХУ нь хэлмэгдэн хохирч буй араб түмний талд ам хэлээрээ төдийгүй ажил үйлээрээ хатуу зогсох болно гэж мэдэгдсэн нь<sup>27</sup> түрэмгийлэгчдэд өгсөн доривтой сануулга болсон билээ. Социализмын бүх орон, нийт шударга улс түмний санаа зоригийн илэрхийлэл гэж бүрэн үзэх үндэстэй зөвлөлт засгийн газрын тэрхүү чухал баримт бичигт ямар ч болзолгүйгээр түрэмгий цэргээ татан гаргахыг Израилд шаардаад НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрүүд заавал биелэгдэх ёстой гэдгийг дурьдан, булаан эзэлж хавсарган нэгтгэх зорилготой энэхүү түрэмгийлэл энэ удаад ЗХУ-ын улсын хилээс тийм ч хол бус газар дайны түймэр шатааж байна гэдгийг ноцтой анхааруулсан юм. Арабын бараг бүх орны засгийн газрууд, олон нийт хэрэг явдлын мөн чанарыг голч шударгаар тодорхойлж, асуудлыг шийдвэрлэх бодитой арга зам сүвэгчилсэн ухаалаг, буурьтай арга хэмжээ хэмээн зөвлөлтийн мэдэгдлийг сайшаан хүлээн авчээ. Зөвлөлтийн сэтгүүлч Л. Вольновтой Ливаны ерөнхийлөгч агсан С. Франжьегийн ярилцсан ярилцлагаас иш татья: «ЗХУ-ын баримталж байгаа байр суурийн төлөөнөө энэхүү аугаа их орны удирдагчдад миний бие талархлын үг өргөхийг хүсэж байна. Хүний зовлон жаргалыг мэдэрч, хүний эрхийн Тунхаглалыг хүндэтгэн биелүүлэгч хүмүүс энэхүү ертөнц дээр бас байгаа юм байна шүү гэдэг итгэлийг зөвлөлтийн байр суурь бидэнд бу- цааж төрүүллээ. Бусад улс гүрэн, түүний дотор аман дээрээ хүний эрхийн Тунхаглалыг хүндэтгэхийг уриалж, ажил хэрэг дээрээ болохоор бүхэл бүтэн ард түмнийг хядаж буйн төлөө цэргийн гэмт хэрэгтнүүдийг өгөөмөрөөр хөхүүлэн шагнаж буй АНУ, ЗХУ-ын үлгэр дууриаллыг аваасай билээ гэж бид хүсэж байна»<sup>28</sup> хэмээн Ливаны улс төрийн нэрт зүт- гэлтэн тэгэхэд тэмдэглэжээ.

Олон улсын дундын байдлын зангилгаа чухал асуудлуудаар БНМАУ-ын баримталж ирсэн байр суурь бол бодит социализмын уялдан зохи-

26. «Международная жизнь», № 5, 1982 с. 38.

27. «Правда» 15 июня 1982 г.

28. «За рубежом». № 26, 1982, с. 7.

цолдсон гадаад бодлогын өвөрмөц тод илэрхийлэл байдгийг нийтээр мэдэх билээ. Манай нам төрийн тэргүүн Ю.Цэдэнбал, Л.И.Брежневтэй 1982 оны 8-р сард уулзсан уулзалтын дараа хамтарсан мэдэгдэлдээ: «Салан тусгаарлах арга ажиллагаа, Израилийн сонгон авсан шиг аллага хүчирхийлэлийн аль алинаар Ойрхи Дорно дахинаа бат бэх энх тайвныг тогтоох боломжгүй юм. Гагцхүү шударга хийгээд бүхнийг хамарсан улс төрийн зохицуулалт л Ойрхи Дорнод эцгийн гал голомт нь болж буй бүх ард түмний амин чухал эрхийг найдвартай хангах болно»<sup>29</sup> гэсэн билээ.

Йемений социалист намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНАЙАУ-ын Дээд зөвлөлийн тэргүүлэгчдийн дарга, ерөнхий сайд А. Н. Мухамедыг өнгөрсөн намар Москвад ирэх үеэр Зөвлөлтийн талаас дэвшүүлсэн 6 зүйл зарчим<sup>30</sup> бол дээр өгүүлсэн олон улсын бага хурлын хүрээнд асуудлыг авч хэлэлцэж, даруй 30 жилийн турш үргэлжилсэн 5 дайны нүүр үзэж буй Ойрхи Дорнод дахь архагшсан хямралын голомтыг устгаж энх тайван тогтоох цорын ганц арга зам мөн гэж БНМАУ, Монголын олон нийт үзэж дэмжиж байгаа юм.

1982 оны 9-р сарын 1-нд АНУ-ын ерөнхийлөгчийн дэвшүүлсэн «энх тайванч» санаачлага гэгчийн далбаан дор Иордани голын баруун эрэг, Газын бүсэнд ««мөлхөх маягаар хавсарган нэгтгэх» Израилийн бодлого хэрэгжин газар авч, Ливан улсын нутаг Бекаагийн талд түрэмгийлэгчдийн цэрэг бөөгнөрч буй одоогийн нөхцөл байдалд зөвлөлтийн санал, зарчимд тулгуурласан энх тайвны доривтой алхамыг сонирхогч бүх тал нэн даруй хамтран хийхгүй болбоос түрүү түрүүчийн дайны утаа замхарч гүйцээгүй байхад шинэ аюул занал дахин нүүрэлж болохыг Ойрхи Дорнотын улс дундын харилцанн гурван арван жилийн түүх нотлон зааж байна.

Гэвч ЗХУКН-ын Төв Хорооны II-р сарын ээлжит бус бүгд хурал дээр Ю.В.Андроповын онч товчоор хэлсэнчлэн<sup>31</sup> улирах цагийн үзэгдэл төдийгүй, одоо ба ирээдүйн амин чухал үйл явдал хэвээр байх дэлхий дахины намжмал байдлын дэвсгэр дээр Ойрхи Дорнотын сөргөлдөөн ч тайвнаар зохицон шийдвэрлэгдэж болно, тиймд хүргэх хүч уул бүс нутгийн хүн ард, бүхэл хүн төрөлхтөнд бий гэдэгт монголын олон нийт итгэж байна.

## **ВОЙНА ПРОТИВ ЛИВАНА: ПРИЧИНЫ ВОЗНИКНОВЕНИЯ, И СУЩНОСТЬ.**

### **(Р е з ю м е)**

В 1943 году в результате расширения национально-освободительного движения и после отмены некоторых статей конституции, ограничивавших суверенитет страны, Ливан был провозглашен независимым государством. Однако французские войска были выведены из Ливана лишь в 1946 году, после чего, особенно начиная с середины 60-х годов, страна превращается в объект колониальной империалистической политики США и Израиля.

Глубокий общественный и политический кризис внутри Ливана, раскол в арабском мире, в частности, отход Египта от общего национально-

29. «Правда» 22 августа 1982 г.

30. «Правда» 18 октября 1982 г.

31. «Правда» 13 ноября 1982.

освободительного движения региона, ирако-иракская война и, не в последнюю очередь, усиление вооруженной борьбы палестинского народа за свое существование, явились факторами, подтолкнувшими Израиль к вооруженной агрессии. Факты необратимо свидетельствуют, что израильская агрессия была подготовлена и проходила при полном содействии США.

Вторжение в Ливан преследовало следующие цели: во-первых, уничтожить движение сопротивления ООП и палестинский народ, во-вторых, аннексировать южную часть страны и, в-третьих, создать правительство Ливана наподобие режима в Египте, втянув, таким образом, Ливан в орбиту Кэмп-Дэвидской сделки.

Несмотря на военную и политическую поддержку США, израильская военщина не добилась осуществления своих целей. Более того, варварская агрессия и политика геноцида в отношении палестинского народа вызвала гневное возмущение во всем мире и привела к изоляции Израиля на международной арене.

Советский Союз неоднократно выступал с предложениями и конкретными инициативами по мирному решению ближневосточной проблемы. Советские предложения, направленные на скорейшую ликвидацию опасного военного очага на Ближнем Востоке, отличаются большой содержательностью и высокой принципиальностью, отвечающие интересам всех арабских государств. Созыв международной конференции и решение проблемы на основе 6-ти принципов, выдвинутых Л.И.Брежневым в августе сего года, есть необходимые условия ликвидации реальной угрозы возникновения новой войны на Ближнем Востоке.

Общественность МНР твердо верит, что урегулирование ближневосточного кризиса должны происходить мирным путем, на основе разрядки. Возможные пути такого решения проблемы имеются у народов арабского мира.